

Засгийн газрын тусгай сангуудаар хэрэгжүүлэх арга хэмжээнүүд болон түүний төлөвлөлт

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг 2006 онд батлагдсанаар тусгай сангийн төрлийг тогтоож, эдгээр санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулж ирсэн. 2009-2011 оны дунд хугацааны төсвийн төлөвлөлтөөр Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор 2009 оны төсвийн төсөлд тусгай сангуудаар хэрэгжүүлэх арга хэмжээнүүд болон түүнд зарцуулах хөрөнгийн төсөвлөлтийн талаар тусгалаа.

Аялал жуучлалын сан.

Тус сан нь Дэд бүтцийн сайдын 2004 оны 40 тоот тушаалаар Иргэний Нисэхийн Ерөнхий газраас олон улсын нисэх буудлаар үйлчлүүлсэн олон улсын нислэгийн зорчигчдын хураамжийн орлогын 8 хувьтай тэнцэх хөрөнгийг аэронагивацийн бус орлогоос аялал жуучлалын санг бүрдүүлж ирсэн. Жил бүрийн төсөвт дээрх эх үүсвэрээс Аялал жуучлалын санд 240.0 сая төгрөгийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлж түүгээр сангийн үйл ажиллагааг явуулан Улсын төсөвт тусган төлөвлөж ирсэн.

Байгаль хамгаалах сан.

Байгаль хамгаалах санд өмнөх оны хэмжээгээр буюу 259.4 сая төгрөг тусгав. Гадаадын анчидаар агнуулах ан амьтны төлбөрийн орлогын 10 хувь, байгаль орчны чиглэлээр мэргэжлийн байгуулагуудад эрх олгох хураамжийн төлбөрийн орлогоос санхүүжүүлэхээр тусгав.

Эрсдлийн сан.

Тус сангийн хөрөнгийг хуулинд заасны дагуу гамшгийн улмаас хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн экспорт хязгаарлагдах, олон улсын санхүүгийн зах зээлд чөлөөт валютын ханш огцом өөрчлөгдөх, гамшиг болон урьдчилан тооцох боломжгүй бусад нөхцөл байдал үүссэний улмаас дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурах зэргээс төсвийн орлого буурч, зарлага нэмэгдсэн тохиолдолд зарцуулах зорилгоор 2009 онд эрсдлийн санг 9.2 тэрбум төгрөгөөр төлөвлөв.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан.

Монгол Улсын “Харилцаа холбооны тухай”, “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийн хүрээнд Засгийн газрын 2006 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн үйлчилгээний санг бүрдүүлэх, зарцуулах журам”-д заасны дагуу сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулан Монгол Улсын Ерөнхий сайдаар батлуулан амжилттай хэрэгжүүлж байна. 2008 онд 3.1 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр 3.1 тэрбум төгрөгийн ажил хийхээр төсөвлөсөн боловч эхний хагас жилийн байдлаар 731.4 сая төгрөгийн ажил хийгээд байна.

Дархлаажуулалтын сан.

Монгол Улсын Дархлаажуулалтын тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх бодлогын хүрээнд халдварт өвчнөөс сэргийлэх, түүний тархалтыг хязгаарлах, өвчнийг устгах зорилгоор дархлаажуулалтын сангийн эх үүсвэрийг 2009 оны төсвийн төсөлд 2.0 тэрбум төгрөгөөр тооцсон нь 2008 оны батлагдсан төсвөөс даруй 2.0 дахин өслөө.

Дархлаажуулалтын сангийн бүрэлдэхүүнийг хүснэгтээр үзүүлбэл:

| № | Вакцин, биобэлдмэлийн нэр, төрөл | Үнэ /сая төгрөгөөр/ |
|---|--|---------------------|
| 1 | Үндэсний товлолоор хийх Халдварт саа, сүрьеэгээс сэргийлэх вакцин, Сахуу, хөхүүл ханиад, татран, В гепатит, Улаанбурхан, улаанууд, гахай хавдарын вакцин, Сахуу, татрангийн хоргүйсүүр | 454,306 |
| 2 | Тархвар судлалын заалтаар хийгдэх вакцин, биобэлдмэл | 1,265,989 |
| 3 | Сэргийлэх тарилга, ажил үйлчилгээний жагсаалтаар хийх вакцин, биобэлдмэл | 55,322 |
| 4 | Заавал хийх дархлаажуулалтанд шаардагдах тариур, аюулгүй хайрцаг | 49,506 |
| 5 | Тарваган тахал, боом, хачигт энцефалитын вакцины зүү тариур | 5,042 |
| 6 | Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвд нөөцлөх вакцин, биобэлдмэл | 96,056 |
| 7 | Байгалийн голомтот халдварт өвчин судлалын үндэсний төвд нөөцлөх вакцин, биобэлдмэл | 63,780 |
| 8 | Оношлуур | 10,000 |
| | Нийт дүн | 2,000,000 |

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан.

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих санд улсын төсвөөс санхүүжихээр 1.0 тэрбум төгрөгийг тусгасан нь өмнөх оны хэмжээтэй адил байгаа болно.

Засгийн газрын нөөц сан.

Монгол улсын 2009 оны төсвийн төсөлд Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг 10.0 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн болно.

Мал хамгаалах сан.

Мал сүргийг ган зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2001 оны 246 дугаар тогтоолоор "Мал хамгаалах сан бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах журам"-ыг баталсан байна. 2006 онд гарсан Засгийн газрын "Тусгай сангийн тухай" хуульд мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах асуудал мөн тусгагдсан. Уг сангийн хөрөнгийг бэлчээрийн даацыг тодорхойлох, мал өвөлжүүлэхтэй холбогдсон судалгаа явуулах, хадлан тэжээл бэлтгэх зориулалттай техник технологийн шинэчлэлт хийх, худаг уст цэг шинээр гаргах, сэргээн засварлах зэрэгт үйл ажиллагаанд зарцуулах болно.

"Мал хамгаалах сан"-гаас хийх ажлын төлөвлөгөөг жил бүр Сангийн сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэн хэрэгжүүлж ажиллалаа.

Сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төслүүдийн хүрээнд байран маллагааны саалийн 490 гаруй үнээтэй эрчимжсэн фермерийн аж ахуй 72, мах, сүүний болон махны чиглэлийн үхрийн фермерийн аж ахуй 8, мөн малын ногоон тэжээл тариалж дарш бэлтгэх тэжээлийн цех 16 шинээр бий болохын зэрэгцээ 320 ажлын байр бий боллоо. Өмнө нь хийгдэж байгаад орхигдсон хүчит, шүүст тэжээл бэлтгэх ажил эхэлж, сүүний аж ахуйд эрчимжсэн технологитой үйлдвэрлэл явагдах эхлэл тавигдаж байна.

Соёл, урлаг хөгжүүлэх сан.

Соёлыг хөгжүүлэх, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээг санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгалаа. Үүнд:

- Засгийн газрын 2006 оны 115 дугаар тогтоолын дагуу дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын сан хөмрөгт худалдан авах зардалд 50.0 сая төгрөг, Хөгжмийн том хэмжээний бүтээлийг улсын санд худалдан авах зардалд 50.0 сая төгрөг, кино, ном хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах зардалд 50.0 сая төгрөг,
- Засгийн газрын 2000 оны 55 дугаар тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 110 дугаар тушаалын дагуу олон улсын монгол судлалын үйл ажиллагааг дэмжихэд нийт 10.0 сая төгрөг,
- Засгийн газрын 2005 оны 43 дугаар тогтоолын дагуу морин хуур, уртын дууны хөтөлбөрийн хүрээнд үндэсний уламжлалт бүтээл туурвихад нийт 25.0 сая төгрөг, мөн Засгийн газрын 2007 оны 159 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол хөөмий хөтөлбөрийн санхүүжилтэд нийт 45.0 сая төгрөг,
- Төсвийн хөрөнгөөр бүтээх баримтат кино бүтээхэд 70.0 сая төгрөг, бөгөөд сонгодог урлагийн бүтээл туурвихад 25.0 сая төгрөг,
- Соёл, урлагийн ажилтан, уран бүтээлчдийн мэргэшил дээшлүүлэх сургалт-семинар зохион байгуулах зардалд нийт 45.0 сая төгрөг, гадаад, дотоодод зохиогдох соёл, урлагийн арга хэмжээ, тэмцээнд оролцуулах, уран бүтээлийн үзэсгэлэнг гадаадад болон өөрийн оронд зохион байгуулахад нийт 150.0 сая төгрөг,
- Засгийн газрын 2008 оны 280 дугаар тогтоолын дагуу хүүхдэд уран сайхан, гоо зүйн мэдлэг олгох уран бүтээл туурвих, соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулахад нийт 150.0 сая төгрөг,
- Засгийн газрын 2008 оны 120 дугаар тогтоолын дагуу олон улсын хэмжээний соёл, урлагийн наадам, тэмцээн, үзэсгэлэн, номын яармагт оролцож онцгой амжилт гаргасан соёлын ажилтан, уран бүтээлчдийг шагнаж урамшуулахад нийт 30.0 сая төгрөг,
- Засгийн газрын 2008 оны 195 дугаар тогтоолын дагуу оны шилдэг уран бүтээлч, найруулагч, жүжигчин, зураач, бүжигчиний шагналд нийт 30.0 сая төгрөг,
- Засгийн газрын 2008 оны 303 дугаар тогтоолын дагуу соёлын өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах зардалд нийт 160.0 сая төгрөг,
- Соёл, урлагын судалгаа, шинжилгээ хийх зардалд нийт 50.0 сая төгрөг тус тус тусгалаа.

Сургалтын төрийн сан.

Засгийн газрын 2008 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэл, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 451/318 тоот тушаалын дагуу Сургалтын төрийн сангаас дотоодын их, дээд, сургууль, коллежийн зээл, буцалтгүй тусламжид хамрагдах оюутны тэтгэлгийн санхүүжилтийн хэмжээг өөрчлөн шинэчилсэний дагуу сургалтын төрийн сангийн санхүүжилтийн хэмжээг тооцлоо. Дээд боловсрол эзэмшүүлэхэд сургалтын төлбөрийн жишгийг Засгийн газрын 2007 оны 187 дугаар тогтоолоор сургуулийн байршил, хэв шинжээр баталж мөрдөж байсан бол дээрх тушаалаар Сургалтын төрийн сангаас дамжуулан оюутанд олгох зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтийн хэмжээг суралцагчдын суралцах мэргэжлийн бүлгээр ангилан тогтоосон. Мөн санхүүжилтийн хэмжээг дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын

төлбөрийн хэмжээний 52-90 хүртэл хувиар өсгөн тооцлоо.

Сургалтын төрийн сангийн нийт зардлыг 2009 онд 34.5 тэрбум төгрөгөөр төлөвлөж тооцлоо. Үүнд:

- Дээд боловсролын сургалтын байгууллагад хөнгөлттэй зээлээр суралцагчдад 4.0 тэрбум төгрөг;
- Дээд боловсролын сургалтын байгууллагад буцалтгүй тусламжаар суралцагчдад 9.5 тэрбум төгрөг;
- Төрийн албан хаагчийн нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэхэд 7.7 тэрбум төгрөг;
- Өндөр хөгжилтэй оронд суралцагчдад олгох сургалтын төлбөр, амьжиргааны зардалд 2.8 тэрбум төгрөг;
- Монголоос гадаадад суралцагчдын тэтгэлэгт 163.5 сая төгрөг;
- Удирдлагын академид сумдаас төрийн албан хаагч бэлтгэх зардалд 350.0 сая төгрөг;
- Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид өвлийн амралтаараа орон нутагтаа очих замын зардал 500.0 сая төгрөг тус тус төсөвлөсөн.
- Мөн төрийн бус өмчийн буюу хувийн мэргэжил сургалт-үйлдвэрлэлийн төвүүдэд суралцагчдын сургалтын хувьсах зардал болон суралцагчдад сар бүр олгох амьжиргааны тэтгэлэгийн санхүүжилтийг сургалтын төрийн сангаас хянан санхүүжүүлэхээр сургалтын төрийн санд зардлыг тусгалаа. 2008-2009 оны хичээлийн жилд нийт 9979 хүүхэд мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд хамрагдана гэж тооцож нийт 4.8 тэрбум төгрөгийг сургалтын зардалд, 4.5 тэрбум төгрөгийг амьжиргааны тэтгэлэгт олгохоор төлөвлөв.

Тариалан эрхлэлтийг дэмжих сан.

2004 онд Улсын Их Хурлаар батлагдсан “Тариалангийн тухай” хуульд тариалангийн салбарыг төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын хэрэгжүүлэх бүрэн эрх, тариаланг дэмжих сан, түүний эх үүсвэрийг бүрдүүлэх, Сангийн хөрөнгийг таримал ургамлын үрийн аж ахуйг хөгжүүлэх, тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчээс стандартын шаардлага хангасан үрийн болон хүнсний борлогдоогүй үлдсэн буудайг худалдан авахад зарцуулах талаар болон тариалангийн газартай холбогдсон асуудлаар тодорхой заалтуудыг оруулсан.

“Тариалангийн тухай” хуулийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2005 оны 139 дүгээр тогтоолоор “Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ыг батлуулсан.

2006 онд гарсан “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуульд Тариаланг дэмжих сангийн хөрөнгийг захиран зарцуулах асуудал мөн тусгагдсан.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн яамны дэргэд 2005 оны 06 дугаар сараас эхлэн “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-г бий болгож, аж ахуйн тооцооны журмаар ажиллаж байна.

Уг санг “Буудай сан”-гийн эх үүсвэрт тулгуурлан бүрдүүлсэн бөгөөд 4.3 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, харьяандаа 36.0 мянган тонн багтаамж бүхий Хөтөл, 18.0 мянган тонн багтаамж бүхий Сэлэнгэ, 10.0 мянган тоннын багтаамж бүхий Хархорин, бараа хадгалах Улиастай салбаруудтай, нийт 100 гаруй ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаа нь усалгаатай газар тариаланг хөгжүүлэх, услалтын систем байгуулах, сэргээн засварлах, тариалангийн газрын үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээх, таримал ургамлын үрийн аж ахуйг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн техник, технологийн шинэчлэлт хийх, үйлдвэрлэгчдээс үрийн болон хүнсний улаан буудайг худалдан авах, таваарын тарианы нөөц бүрдүүлэх, тусламжийн бараа, бүтээгдэхүүнийг хадгалах борлуулах санг бүрдүүлэх, үүссэн өр авлагыг барагдуулахад чиглэгдэж байна.

“Атрын 3 дахь аян” газар тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дээрх сан нь олон арга хэмжээнүүдийг авч явуулсан бөгөөд 2009 онд мөн зарим арга хэмжээнүүдийг авч явуулахаар төсвийн төсөлд тусгалаа.

Замын сан /Төлбөр хураах цэг/.

Монгол Улсын “Авто замын тухай”, “Авто тээврийн тухай” хууль болон “Журам батлах, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2007 оны 177 дугаар тогтоолыг үндэслэн Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2005 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 05 тоот тушаалаар “Олон улсын болон улсын чанартай авто зам дээгүүр зорчин явж байгаа авто тээврийн хэрэгслээс төлбөр авах, захиран зарцуулах журам”-ыг батлан Автозам, тээврийн хяналт зохицуулалт, олон улсын болон улсын чанартай автозам дээгүүр зорчиж буй авто тээврийн хэрэгслээс төлбөр авах цэгийн үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Олон улсын болон улсын чанартай авто замаас төлбөр авах 16 цэгүүдэд нийт 108 ажилчид ажиллаж байна. 2009 оны төсвийн төсөлд 876.9 сая төгрөгийг тусгаад байна.

Хилийн чанадад байгаа Монгол иргэдэд туслах сан.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу 500.0 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр шинээр тусгасан болно.

Хүүхдийн төлөө сан.

Хүүхдийн төлөө сан нь 2005 оноос эхлэн Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Монгол Улсын Засгийн газрын тэргүүлдэг Монгол Улсын Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн дэргэд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хүрээнд эх үүсвэрээ хандиваар бүрдүүлэх журмаар зохион байгуулж байгаад Засгийн газрын Тусгай сангийн хууль батлагдсанаас хойш Хүүхдийн төлөө сан нь байгуулагдсан боловч энэ сангийн үйл ажиллагааг хандив дэмжлэгээр эх үүсвэрээр жилд 6.0 орчим сая төгрөгөөр бүрддэг байсан. Харин Монгол Улсын Засгийн газрын 2008 оны Хүүхдийн төлөө сангийн дүрэм, сангийн удирдах зөвлөлийн бүрэлдхүүнийг батлах тухай 261 дүгээр тогтоолоор Сангийн дүрмийг 1 дүгээр хавсралтаар, Сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсан. Тогтоолын 2 дугаар заалтын дагуу сангийн хөрөнгийг жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайдад, Сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайдад тус тус үүрэг болгосон. Энэ эрх зүйн актын хүрээнд Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг бүрдүүлэх, сангаас явуулах үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэрийг ирүүлсэн саналыг үндэслэн тооцон үзэж 2009 оны төсвийн төсөлд 288.3 сая төгрөгийг тусгасан болно. Энэ хөрөнгөөр 2009 оны дараах үйл ажиллагааг явуулахаар төлөвлөдөг байна.

Энэ сан нь Засгийн газрын тусгай сангийн хуульд зааснаар хүүхдийн хөгжил, хамгааллын бодлого, чиглэлд нийцсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүүхдийн эрх ашиг сонирхолыг хамгаалах зорилгоор зарим онцгой нөхцөлд тусламж үзүүлэх, хүүхэд, өсвөр үеийнхэний гишүүнчлэлтэй төрийн бус байгууллагын зарим үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэхэд чиглэгдсний дагуу 2009 оны төсвийн төслөөр Хүүхэд хөгжлийн төв төслийн хүрээнд Хүүхэд залуучуудын нийгэм дэх оролцоог идэвхижүүлэх, багаар ажиллах чадвартай, манлайлагч хамт олон бүрдүүлэх, бүтээлч чадварыг эзэмшүүлж, зөв хүмүүшлийг бий болгон төлөвлүүлэх, эх орон ч бүтээлч сэтгэлгээтэй иргэнийг нийгмийн сайн сайхны төлөө бэлтгэхэд зориулан хүүхэд залуучуудын хөгжилд чиглэсэн олон талт арга хэмжээг зохион байгуулах болон тэднийг хөгжих, зөв төлөвшилийг олгох хөгжлийн сургалт, лекцүүдийг зохион байгуулахад 6.3 сая төгрөг, Миний нэрийн хуудас аян төслийн хүрээнд хүүхэд бүр өөрийн зорилго, тэмүүлэл, хүсэл

эрмэлзэл, түүнд хүрэх арга зам, бахархалт үр дүн бүхий хуудсаа тодорхойлоход хүүхэд өсвөр үеийнхэнд түүх соёлоо дээдэлсэн эх орон ч хүмүүжил олгох, бие даасан өөрийн гэсэн өөдрөг үзэл бодолтой шударга иргэн болон төлөвшихөд дэмжлэг үзүүлэх зорилгоор дээрх аяныг өрнүүлэхэд 60.0 сая төгрөг, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэх төслийн хүрээнд хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн байдал, түүний үр нөлөөг судлан тогтоох, цаашид уг ажлыг чанаржуулах, үр нөлөөтэй байлгах цогц арга хэмжээг боловсруулах замаар хүүхдийн эрх чөлөөг хангах, тэднийг элдэв хэрэг зөрчлөөс ангид байлгах явдлыг дэмжих ажлын хүрээнд онол практикийн бага хурлыг зохион байгуулж үр дүнг хэлэлцүүлэн нийтийн хүртээл болгоход 15.7 сая төгрөг, хүнд нөхцөлд байгаа болон гамшиг ослын үед хүүхдэд тусламж, дэмжлэг, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх арга хэмжээнд 20.0 сая төгрөгийг тус тус төлөвлөөд байна. Эцэг, эх хүүхдийн оролцоо төслийн хүрээнд хэвлэл мэдээлийн хэрэгслийн 30 хүрэхгүй хувийг хүүхдийн тухай мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг эзэлж байгаа өнөө үед олон нийтийн мэдээлийн хэрэгслээр дамжуулан хүүхдийн оролцоог ухуулан сурталчлах нь зайлшгүй чухал болоод байна. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 9.5 сая төгрөгийг төлөвлөсөн болно.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан.

Тус сангийн зорилт нь Мянганы хөгжлийн зорилтод зааснаар 2015 он гэхэд ядуурлыг хоёр дахин бууруулна. 2009 онд 80,000 ажлын байр шинээр бий болгосноор ядуурлыг бууруулахад тодорхой үр дүнд хүрнэ.

Хэрэгжүүлэх стратеги:

- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг орон нутгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний албадаар дамжуулан дэмжих;
- Мэргэжил олгох, жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийн ур чадварыг дээшлүүлэх түр сургалт зохион байгуулах;
- Нийтийг хамарсан ажил зохион байгуулах;
- Ажлын байр бий болгох зорилгоор жижиг зээл олгох;
- Ажилд зуучлах, ажил олгогчдыг дэмжих замаар ажлын байр бий болгох;
- Хөдөлмөр эрхлэлтийн бодлогод хүн амын бүлгүүд, тухайлбал, залуучууд, өсвөр үеийнхэн, эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон албан бус хөдөлмөр эрхлэгчид, малчдад зориулж тусгайлсан хөтөлбөр боловсруулах, энэ чиглэлээр олон улсын байгууллагуудаас дэмжлэг, тусалцаа авах, төсөл хэрэгжүүлэх.

Хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд орох орлогын бүрдүүлэлтийн талаар:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийг бууруулах зорилтын хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2009 онд гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого 25.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөж байна. Мөн түүнчлэн эргэлтийн зээлийн эх үүсвэр 16.7 тэрбум төгрөг, 2008 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар харилцах дансны үлдэгдэл 5.0 тэрбум төгрөг байна. Өөрөөр хэлбэл, 2009 онд хөдөлмөр, ажил эрхлэлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ашиглах нийт эх үүсвэр 46.7 тэрбум төгрөг байна. Үүнээс 16.7 тэрбум төгрөг нь жижиг зээлд олгогдсон эх үүсвэр болно.

2008 оны эхний хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 24.3 мянган иргэн гадаадын иргэн ажиллаж байгаагийн 14.9 мянган хүн буюу 61 хувь нь уул уурхай, олборлох болон боловсруулах үйлдвэр, барилга, худалдаа үйлчилгээний салбарт ажиллаж байгаа бөгөөд нэг ажиллагчийн ажиллах дундаж хугацаа 5.5 сар байна. Энэ жишгээр тооцож үзэхэд 2009 онд 28 мянган хүн гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрт 24.9

тэрбум төгрөг төвлөрүүлэх боломжтой гэсэн тооцоо гарч байгаа бөгөөд энэ нь тухайн жилд тавигдсан зорилтыг бүрэн хэмжээгээр хангах эх үүсвэр болно. Иймд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 16.1-д “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд улсын төсвөөс жил бүр олгох хөрөнгийн хэмжээ нь төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй байна” гэж заасны дагуу төсвөөс авахаар санал болгосон 9.0 тэрбум төгрөгийг заавал олгох шаардлагагүй гэж үзлээ. Сангийн орлогын эх үүсвэрт тооцогдож байгаа гадаадын иргэдийн ажлын байрны төлбөр нь төсвийн орлоготой агуулгын хувьд адил орлого болно.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд 2009 онд тухайн жилд бүрдүүлэх орлогыг бүрэн хэмжээгээр зарцуулахаар төсвийн төслийг боловсруулав.

“Хөдөлмөр, ажил эрхлэлт” хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эх үүсвэрээс санхүүжүүлэх үйл ажиллагааны зардлыг бүтээгдэхүүн тус бүрээр авч үзвэл:

/сая төгрөгөөр/

| | | 2008 төлөвлөгөө | 2009 оны төсөл | Зардлын нийт дүнд эзлэх хувь | Гарах үр дүн, үйл ажиллагаа |
|---|---|--------------------|-------------------|--|---|
| | Нийт дүн | 16,400.0 | 23595.0 | 100.0 | |
| 1 | Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэллээр хангах үйлчилгээ | 600.0 | 700.0 | 3.0 | Хөдөлмөрийн зах зээлийн иж бүрэн мэдээллийн баазыг хөгжүүлж, интернэтэд суурилсан мэдээллийн тогтолцоонд шилжүүлнэ. |
| 2 | Ажил олгогчдыг дэмжих | 941.5 | 1,061.4 | 4.5 | Ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд 1532 хүн хамруулна. |
| 3 | Ажилд зуучлах үйлчилгээ | 400.0 | 386.8 | 1.6 | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан ажил хайгчдыг сул чөлөөтэй ажлын байранд зуучлах үйл ажиллагааг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдээр болон хувийн хөдөлмөр зуучлалын албадаар дамжуулан гэрээлэн гүйцэтгүүлэх бөгөөд хөдөлмөр эрхлэхийг хүссэн 50.0 мянган ажилгүй иргэн, ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэдийг хамруулна |
| 4 | Мэргэжлийн сургалт, давтан сургалт | 1,158.6 | 1,637.8 | 6.9 | Мэргэжил олгох, давтан сургалтад 10650 хүнийг хамруулна. |
| 5 | Мэргэжлийн чиг баримжаа, зөвлөгөө өгөх үйлчилгээ | 400.0 | 410.0 | 1.7 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд бүртгэлтэй ажилгүй иргэд болон албан бус хөдөлмөр эрхлэгчид, малчид зэрэг 50.0 мянган иргэнийг мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээлэлээр хангах үйлчилгээнд хамруулна. |

| | | | | | |
|---|---|---------|---------|------|---|
| 6 | Хөдөлмөр эрхлэлтийн шинэ үйлчилгээ | 2,102.3 | 700.0 | 3.0 | <p>1. Гадаад орны хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны туршлага судлах;</p> <p>2. Шинэ үйлчилгээ, арга хэмжээг туршин нэвтрүүлэх /мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр хоршоо, нөхөрлөл, өрхийн болон фермерийн аж ахуйг говь, төвийн бүсэд туршин нэвтрүүлэх/;</p> <p>3. Өмнөговь, Төв аймаг, Багануур дүүрэгт хөдөлмөр, халамжийн үйлчилгээний нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлэх;</p> <p>4. Хамгийн олон ажлын байр бий болгосон ажил олгогч нарыг шалгаруулах;</p> <p>5. Албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан зохион байгуулалттай болгох чиглэлээр туршилтын 2 төслийг хэрэгжүүлэх.</p> |
| 7 | Хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан жижиг зээл | 8,315.0 | 15360.0 | 65.1 | <p>Хувиараа болон өрхийн аж ахуй, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хүсэгч ажилгүй иргэн, түүнчлэн малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчдэд жижиг бизнесийг дэмжих чиглэлээр Засгийн газрын 2006 оны 166 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, зээлийн хүү нөхөн төлөх журам"-ын дагуу банк, банк бус санхүүгийн байгууллагуудаар дамжуулан жижиг зээл олгох замаар шинээр 15000 ажлын байрыг бий болгоно.</p> |
| 8 | Бизнесийн инкубацийн үйлчилгээ | 878.0 | 650.0 | 2.8 | <p>Хувиараа болон өрхийн аж ахуйг өргөжүүлэх замаар тогтвортой ажлын байр бий болгох. Энэ үйлчилгээнд 7500 иргэн хамрагдана.</p> |
| 9 | Бизнес эрхлэх талаарх сургалт | 449.6 | 600.0 | 2.5 | <p>1. Аж ахуй эрхлэлтийн сургалтад 10000 малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг хамруулна. /нэг хүнд ногдох сургалтын зардал 60.0 мянган төгрөг/</p> <p>2. Төсөл хөтөлбөр боловсруулахад нь арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангахад 5000 хүн хамруулна.</p> |

| | | | | | |
|----|--|---------|---------|-----|--|
| 10 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ зохион байгуулах | | 530.0 | 2.2 | 1. Хөдөлмөрийн зах зээлд бие даан оролцох боломжгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор байгуулагдсан хөдөлмөр сургалтын төв, аж ахуйн нэгж, байгууллагын дэргэдэх үйлдвэрлэлийн тусгай үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх; 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирох ур чадварыг сорилын аргаар тодорхойлж, дүгнэлт гаргасны үндсэн дээр хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээг 1000 хүнд үзүүлнэ; 3. Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу шалгаруулж 30 аж ахуй нэгжийг урамшуулах. |
| 11 | Жижиг бизнес эрхлэгчдэд зориулсан арга зүйн зөвлөгөө | 150.0 | 300.0 | 1.3 | Жижиг зээл авах төсөл ,хөтөлбөр боловсруулахад нь арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангахад 5000 хүн хамруулна. |
| 12 | Нийтийг хамарсан ажил | 1,005.0 | 1,260.0 | 5.4 | Нийтийг хамарсан ажилд ажилгүй, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамруулж түр ажлын байраар хангана. Орон нутгийн чанартай арга хэмжээнд 9000, улсын чанартай дэд бүтцийн төсөл, хөтөлбөрт 1500 иргэнийг тус тус хамруулна. |

Дээрх хүснэгтээс үзэхэд нийт зардлын 60 хувь буюу 10.0 тэрбум төгрөгийг хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан жижиг зээлийн эх үүсвэрт зарцуулахаар байна.

Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан.

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 258 дугаар тогтоолоор “Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан /ХОХС/-гийн хөрөнгийг захиран зарцуулах журам”-ыг баталж, Ерөнхий Сайдын 2007 оны 18 дугаар захирамжаар тус сангийн удирдах Зөвлөлийг байгуулснаар тус сангийн үйл ажиллагаа эхэлсэн.

УИХ-аас 2008 онд “Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан”-д 30.0 тэрбум төгрөгийг зарцуулахаар баталсан бөгөөд УИХ-аас өгсөн чиглэлийн дагуу уг эх үүсвэрийн 15.0 тэрбум төгрөгийн зээлийг хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэгчдэд, үлдэх 15.0 тэрбум төгрөгийн зээлийг зам тээвэр, аялал жуулчлал, үйлдвэр, худалдаа, эрчим хүчний салбарын үйлдвэрлэгчдэд 5-аас доошгүй жилийн хугацаатай, жилийн 15-аас дээшгүй хувийн хүүтэйгээр арилжааны банкнаас олгосон нөхцөлд хүүгийн 50 хувийн төлбөрийг төр хариуцаж “Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан”-гаас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

2008 он гарсаар тус сангаас 127 аж ахуйн нэгж, иргэдэд нийт 18.23 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн урамшууллыг зохих журмын дагуу Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангасан Анод, Голомт, Зоос, Капитрон, Монгол шуудан, Улаанбаатар хотын, ХААН, Чингис хаан, Үндэсний хөрөнгө оруулалт, Хас болон Худалдаа хөгжлийн банкуудаар дамжуулан олгосон байна.

Өнгөрсөн 2007 онд ХОХС-гаас дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулан 8.9 тэрбум төгрөгийг нийт 4 байгууллагад зээлдүүлснээс, зээлийн хүүгийн төлбөрт нийт 535.4 сая төгрөгийн бүрдүүлэлт хийгээд байна.

Шинжлэх ухаан, технологийн сан.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын нэгдсэн саналыг үндэслэн 2009 онд Засгийн газрын захиалгаар хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн онолын суурь судалгаа хийх, Засгийн газрын /улсын/ захиалгатай шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх болон эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх төсөл арга хэмжээний зардалд нийт 4.7 тэрбум төгрөгийг шинжлэх ухаан, технологийн сангийн төсөвт тусгалаа

Эрүүл мэндийг дэмжих сан.

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Тамхины хяналтын тухай хуулийн дагуу Эрүүл мэндийг дэмжих сангийн 2009 оны хөрөнгө 2009 оны төсвийн төслөөр 832.0 сая төгрөг болж 2008 оны төсвөөс 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүллээ. Сангийн хөрөнгийг хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт бус өвчнийг нөхцөлдүүлэгч, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлүүд болон тамхи, архины хэрэглээг бууруулах, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангахад зарцуулахаар төлөвлөлөө.

Монгол Улсыг хөгжүүлэх сан.

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хууль 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдөр батлагдан Монгол Улсыг хөгжүүлэх сан байгуулагдсан. Уг хуулиар Монгол Улсыг хөгжүүлэх сан нь Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн орлогын албан татварын орлого, Монгол Улсын төсвийн өмнөх оны ашиг, улсын төсвийн эрсдлийн сангийн зарцуулагдаагүй хөрөнгө, сангийн үлдэгдэлд төлсөн хүүгийн орлого болон бусад орлогоос бүрддэг.

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийг 3 үндсэн зориулалтаар зарцуулдаг:

1. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн төсвийн орлогын дутагдлыг нөхөх - Улс орныг бүхэлд нь хамарсан гамшиг тохиолдсон, эсхүл зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуульд заасан ашигт малтмалын дэлхийн зах зээл дэх үнэ огцом буурснаас улсын төсвийн орлого буурч, Засгийн газар бүх нөөцөө дайчилсны дараа төсвийн орлогын дутагдал нөхөгдөөгүй тохиолдолд сангийн энэхүү хэсгийг зарцуулахаар Монгол улсыг хөгжүүлэх сангийн тухай хуульд заасан.
2. Улсын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, жижиг, дунд бизнес /аж ахуйн үйл ажиллагаа/-ийг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалт – Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар 2007 онд нийт 161.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ санхүүжигдэж, 2008 оны төсвийн тодотголд нийт 300.2 тэрбум төгрөгийн хөрөнгийн оруулалт, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төсөл боловсруулаад байна.
3. Хүүхэд, гэр бүлийг дэмжих – Хүүхдэд олгох тэтгэмж, 2007 оныг дуустал Үдийн цай хөтөлбөрийн хөрөнгийг санхүүжүүлсэн. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны төсвийн тодотголд нийт 104.6 тэрбум төгрөгийг Хүүхдэд олгох тэтгэмжид, ямааны ноолуурын үнийн зөрүүг малчдад олгоход 30.5 тэрбум төгрөгийг зарцуулахаар тодотголоор тусгасан.